



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 онь 01 сарын 22 өдөр

Дугаар A119

Хэрлэн сум


**Ажлын байрны
тодорхойлолт батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Сум дундын ойн ангийн даргын ажлын байрны тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Б.Золбоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 22 -ний өдрийн
А/79 дугаар захирамжийн хавсралт

АЛБАН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Сум дундын ойн анги

Нэгжийн нэр:

-

Албан тушаалын нэр:

Дарга

Албан тушаалын ангилал,
зэрэглэл:

Төрийн үйлчилгээ, ТҮ-11

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны
байршил:

Хэнтий аймаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЖЛЫН БАЙРНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Ажлын байрны зорилго:

Харъяалагдах газар нутгийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар явуулж буй бодлого болон менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, мэдээллийн санг бүрдүүлэх, ажилтан, албан хаагчдыг удирдлага, зохион байгуулалтаар

хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцна.

Ажлын байрны зорилт:

1.Ой түүний дагалт баялаг төрөл зүйлийг тогтвортой ашиглах, хамгаалах нөхөн сэргээх талаар ойн тухай хууль тогтоомжид заасан чиг үүргийг гүйцэтгэх, үр дүнг тооцох, тайлагнах, ойн ангийн ажилтан, албан хаагчдыг удирдлага, зохион байгуулалтаар хангах,

2.Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж буй бодлогыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн ойн бодлого, зохицуулалтын үйлчилгээ үзүүлэх ажлыг зөвлөмж, мэдээлэл, удирдлага, зохион байгуулалтаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх,

3.Жил бүр ашиглах ойн нөөцийн дээд хэмжээг хууль тогтоомжийн дагуу тогтоох, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих, ойн ангийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлөөр хангах, хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Ажлын байрны гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх – Г, Хянах – Х, Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Харъяалагдах газар нутгийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх хөтөлбөр болон менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, 2. Ойн баялаг ашигласны төлбөр, хураамжийг ноогдуулж, гүйцэтгэлийг хянах, 3. Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж албан байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх 4. Бэлтгэсэн мод, модон материалд эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлого хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1. Иргэдэд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах 2. Нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, зөрчилийг арилгах 3. Ойн тухай хууль бусад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандарт болон холбогдох заавар журмыг чанд мөрдөж ажиллах	Бодлого шийдвэрийг иргэн, хуулийн этгээдэд шуурхай хүргэсэн байна.	Г, Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	1. Экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт мод, ойн дагалт нөөцийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох,	Хууль тогтоомжийн хэрэгжилт	Г, Х, Ш

	2. Ойн нөөцийн төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, нөөцийн өөрчлөлт ашиглалт хамгаалалтын байдлыг хянах,	хангагдсан байна.	
	3. Ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчин зэрэг байгалийн гэнэтийн аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх хамгаалах, тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх.		

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	Ойн аж ахуй /082/, Хүрээлэн буй орчин /052/, Биологи ба холбогдох шинжлэх ухаан /051/, Агрономич /081109/, Эрх зүй /042/, Боловсрол /011/, Эдийн засаг /0311/, Бизнес ба удирдахуй /041/.		
Мэргэшил	Ойн судлал, экологи, байгаль хамгааллын чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно		
Туршлага	Мэргэжлээрээ 3-с доошгүй жил ажилласан байх. Төрийн албаны албан тушаалд ажиллаж байсан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, харьцуулах, дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах - шийдвэрийн эерэг болон сөрөг үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх - судалгааны арга зүй эзэмшсэн байх бусад	
	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжид нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - албан үүргээ хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - бусад	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - нээлттэй, шударга байх.	
	Бусад	- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх, - зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - компьютерын хэрэглээний програм, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;	

		- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;
--	--	---

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хэнтий аймгийн Засаг дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> Сум дундын ойн ангийн ажилтан, албан хаагчид	<u>Бусад харилцах субъект :</u> - Аймгийн Засаг даргын Тамгын газар, - Байгаль орчны газрын Ойн алба, - Сумдын Засаг даргын Тамгын газар, - Ойн мэргэжлийн байгууллагууд.
---	---

V.АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Э.МӨНХ-ЭРДЭНЭ

20..... оны ... дүгээр сарын ... -ны өдөр

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан

Байгууллагын нэр:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ

20..... оны ... дүгээр сарын ... -ны өдөр

